

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НУТАГТ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД  
БАЙДЛЫН САНААЧЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024.03.11

Дархан-Уул аймаг

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилт	Хувь
<b>1. Зохион байгуулалтын ажлын хүрээнд</b>			
1	Дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах.	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын Дэд зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 2023 оны дэд зөвлөлийн төлөвлөгөөний дагуу 2 чиглэлийн 8 ажлын хүрээнд ажлын хэрэгжилттэй танилцан, зарим тулгамдсан асуудлуудын талаар ярилцан, холбогдох шийдвэрүүдийг гаргасан.</p> <p>Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар онлайн орчинд видео шторк 3, сэрэмжлүүлэх самбар, хулдаасан хэвлэл 2, гарын авлага, зурагт хуудас 180, 1 удаагийн дэд зөвлөлийн “Төвийн бүсийн чуулга уулзалт” хэлэлцүүлэг, 2 удаагийн онлайн хуралд оролцсон.</p> <p>Мөн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилагын ажлын алба”-наас зохион байгуулсан онлайн хуралд 2 удаагийн оролцсон.</p>	100%
2	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгааг гаргах, мэдээллийг дэд зөвлөлийн гишүүд, сумдад хүргүүлэх.	Дархан-Уул аймгийн нутагт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч 18 аж ахуйн нэгжийн судалгааг нарийвчлан гаргаж <a href="http://Darkhan.gov.mn">Darkhan.gov.mn</a> цахим сайтын ил тод мэдээллийн санд байршуулж олон нийтэд нээлттэй мэдээлсэн.	100%
3	Орон нутагт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ тайлан ОУИТБС-ын сүлжээгээр гаргах, аймгийн цахим хуудас дээр байршуулах.	<p>Дархан-Уул аймгийн нутагт дэвсгэрт ашигт малтмал, газрын тосны хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулдаг 34 аж ахуйн нэгжийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн барьцаа, албан татвар, хураамжийн орлогын тайлан мэдээ болон нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн ажлыг нийтэд ил тод мэдээлсэн.</p> <p>Орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад ашигт малтмалын хайгуул, олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг 8 аж ахуй нэгжүүдээс 355,9 сая.төгрөг, төрийн бус байгууллагуудад 3 аж ахуйн нэгжүүдээс 9,9 сая.төгрөг, нийт 365,8 сая.төгрөгийн мөнгөн хандив, дэмжлэгийг төвлөрүүлсэн тайланг 2023 оны 05 сарын 05-ны дотор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын албаны цахимд байршуулсан.</p> <p>2023 оны тайлан, мэдээг хуулийн хугацаанд мэдээлж ажиллах болно.</p>	100%
4	Аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын ашиглалт, хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн судалгаа бүртгэлийг шинэчлэж мэдээллийн санг үүсгэх.	Аймгийн нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 10 аж ахуйн нэгжийн 1371.27 га, хайгуулын 8 аж ахуйн нэгжийн 1013,88 га талбай эзэмшигчдийн судалгааг шинэчлэн гаргаж <a href="http://Darkhan.gov.mn">Darkhan.gov.mn</a> цахим сайтад байршуулсан.	100%

5	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын байдалд холбогдох газартай хамтран хяналт тавьж ажиллах.	<p>2023 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөө тайланг хянан баталж, мэдээллийн санд оруулсан. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 15 аж ахуй нэгжийн байгаль хамгаалах нөхөн сэргээх ажилд зарцуулах зардал 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалтын байдалд холбогдох газартай хамтран хяналт тавьж ажиллаж байна.</p> <p>Мөн БОМТөлөвлөгөө тайланг хянан батлах, БОНБҮнэлгээ хийлгэхээр хүсэлт гаргасан иргэд, ААНэгжүүдийн өргөдөл хүсэлт нь хуулийн дагуу шийдвэрлэж ажиллаж байна.</p>	70%
6	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргуулах.	<p>2023 онд 40 ААНэгжийн байгууллагын байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавьж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг мэдээллийн санд оруулах заавар зөвлөмж өгч ажилласан.</p> <p>Ажлын хэсгийн хурлаар 40 ААНэгж байгууллагын байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, тайланг хянаж, үнэлгээний дүгнэлт гаргасан.</p>	100%
7	Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган <a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a> сайтад шинээр байгуулсан гэрээг байршуулах.	<p>Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй сумдын Засаг даргын Тамгын газар нь Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, тохижилт үйлчилгээний чиглэлээр Шарын гол сум 1 аж ахуйн нэгж, 1 бичил уурхайн нөхөрлөлтэй, Хонгор сум 9 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэрээний биелэлтийг хангуулан ажиллаж байна.</p> <p>Энэхүү хамтран ажиллах гэрээний хүрээнд 12 төсөл арга хэмжээг 640,4 сая.төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр харилцан тохиролцож хамтран ажилласан.</p> <p>Сумдын Засаг даргын Тамгын газар нь байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд хамтран ажиллахаар байгуулсан гэрээг Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн /<a href="http://www.iltodgeree.mn">www.iltodgeree.mn</a>/ цахим санд байршуулж гэрээний ил тод байдлыг хангуулж ажилласан.</p>	100%
8	Монгол Улсын Ерөнхийлөгчийн саначилгаар хэрэгжүүлж буй "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхай, хүнд үйлдвэр, газрын тосны салбарт тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн мод тарих үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах.	<p>ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөний хүрээнд уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэшигч Идэрхайрхан ХХК, Шарын гол ХК, Дархан молор эрдэнэ ХХК, Монрок ХХК, Барилга Орд ХХК, Сибизи ХХК, зэрэг 6 аж ахуйн нэгжүүд 3100 ширхэг мод, газар тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 8 шатахуун түгээх станцууд 1400 ширхэг, нийт 4500 ширхэг модыг 400 ажилтан албан хаагч хамрагдаж тарьсан.</p>	100%



9	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд орон нутгийн Дэд зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх зорилгоор түүний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.</p>	<p>Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлын Дэд зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж 2023 оны дэд зөвлөлийн төлөвлөгөөний дагуу 2 чиглэлийн 8 ажлын хүрээнд ажлын хэрэгжилттэй танилцан, зарим тулгамдсан асуудлуудын талаар ярилцан, холбогдох шийдвэрүүдийг гаргасан.</p> <p>Олборлох үйлдвэрлэлийн үйл ажиллагааны талаар онлайн орчинд видео шторк 3, сэрэмжлүүлэх самбар, хулдаасан хэвлэл 2, гарын авлага, зурагт хуудас 180, 1 удаагийн дэд зөвлөлийн “Төвийн бүсийн чуулга уулзалт” хэлэлцүүлэг, 2 удаагийн онлайн хуралд оролцсон.</p> <p>Мөн “Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилагын ажлын алба”-наас зохион байгуулсан онлайн хуралд 2 удаагийн оролцсон.</p>	100%
<p><b>2. Иргэдэд ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд</b></p>			
10	<p>ОУИТБС-ын аймгийн дэд зөвлөлийн хурлыг зохион байгуулах, уул уурхайн холбогдох сургалт зөвлөгөөнд дэд зөвлөлийн гишүүдийг оролцуулах.</p>	<p>Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилагын ажлын албаны дэд зөвлөлийн уулзалт болон “Төвийн бүсийн аймгуудын олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын нэгдсэн чуулга, уулзалт”-ыг 2023 оны 07 дугаар сарын 04-05-ны өдрүүдэд аймагтаа амжилттай зохион байгуулсан. Чуулга уулзалтад Төв, Сэлэнгэ, Говьсүмбэр, Дархан-Уул аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг хамруулан 80 гаруй төлөөлөл оролцсон.</p> <p>Энэхүү чуулга уулзалтаар төрийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн зөвлөмж гаргаснаар аймгуудын Засаг даргын Тамгын газар 4 заалт бүхий зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Мөн салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын 2022 оны 295 дугаар тогтоолоор Орон нутаг дахь төлөөлөгчийн газрыг бүсчилсэн байдлаар 6 бүс /Баруун, Хойд, Хангай, Говь, Төв, Зүүн/ болгон зохион байгуулсан. Манай аймаг хойд бүсэд хамрагдаж “Хойд бүсийн төлөөлөгчийн газар” нь Сэлэнгэ аймгийн төвд байрлан үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.</p> <p>Энэхүү “Хойд бүсийн төлөөлөгчийн газар” нь Ашигт малтмал, газрын тосны салбартай үйл ажиллагааг тогтвортой тасралтгүй явуулахад төрийн болон орон нутгийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран ажиллах, үйл ажиллагааг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, судалгаа хийх, санал боловсруулах, олон нийтэд сурталчлан таниулахад хамтран ажиллах нөхцөл боломж бүрдсэн.</p> <p>Байгаль орчныг хамгаалах, уул уурхайн салбарт сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр 2023 оны 3-р улиралд Сэлэнгэ аймагт зохион байгуулагдсан Planet Gold төслийн сургалт зөвлөгөөнд БОАЖГ, Шарын гол</p>	100%

		сумын 5 бичил уурхайн 10 нөхөрлөлүүдийг хамруулж сургалт, зөвлөгөө зохион байгуулагдсан	
11	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай байгуулах хамтран ажиллах гэрээг үнэлэх, санал гаргах хамтын ажиллагааны хороо байгуулах.	<p>Дархан-Уул аймгийн Хонгор, Шарын гол сумын нутагт 4 байршилд нийт 187 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх гэрээ хийгдсэн.</p> <p>БОАЖЯ, Ойн газар, аймгийн ЗДТГ болон “Оюу толгой” аймгийн Хонгор сумын нутагт орших Их ноёны ам, Бага ноёны ам, Шарын гол сумын Хургадын ам, Шарын гол сумын нутагт орших Цагаан хөтөл орчмын 4 байршилд нийт 187 га газарт техникийн нөхөн сэргээлт хийх ажлын “Хамтран ажиллах гэрээ” хийгдсэн.</p> <p>Хариуцлагагүй уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрч, эзэнгүй орхигдсон газруудыг нөхөн сэргээх, хамгаалах, цаашид хууль бус алт олборлолт явуулахгүй байх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ач холбогдлыг гэрээнд тусган хэрэгжүүлнэ.</p>	100%
12	Салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах ажлыг харьяа байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	<p>Уул уурхайн салбарын 1 удаагийн мэдээллийг байгууллагын ВЭБ ХУУДАС, FACEBOOK хаягаар онлайн орчинд иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.</p> <p>Мөн БОАЖЯ, Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын ажлын алба зэрэг байгууллагуудаас хийсэн онлайн хуралд 2 удаагийн мэдээлэл хийж ололцоог хангасан.</p> <p>Уул уурхайн салбарт мөрдөгдөж буй төрийн бодлого, хууль тогтоомжийг олон нийтэд сурталчлан, таниулж, иргэд, төрийн захиргааны байгууллагын үнэн зөв мэдээ, мэдээллээр ханган ажиллаж байна.</p>	100%
<b>3. Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд</b>			
13	Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сумдын дэд зөвлөлийг чадавхжуулах сургалт зохион байгуулах. /Шарын гол, Хонгор, Орхон сумд/	Шарын гол сум, Хонгор сум, Орхон суманд төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сумдын дэд зөвлөлийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан.	70%
14	Орон нутагт ашигт малтмалыг хууль бусаар олборлохыг таслан зогсоох ажлыг санаачлан орон нутгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	“Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2023 оны 04 сарын 06-ны өдрийн 01-А/87 дугаартай захирамжаар “Хүрээлэн байгаа орчны эсрэг” гэмт хэрэг, зөрчил, ой хээрийн түймэр зэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор ашигт малтмалын нөөц, ордтой, ойн сан бүхий Сэлэнгэ аймгийн Ерөө, Мандал, Баянгол, Бугант, Хүдэр, Жавхлант, сумуудтай холбосон авто замын гол зангилаа бүхий тодорхой газарт Шарын гол сумын Санжинт баг “Цагаан хөтөл” гэх газарт Хяналтын 1 дүгээр цэг, Хонгор сумын 2 дугаар баг “Цэхэр цөөрөм” гэх газарт Хяналтын 2 дугаар цэг, Хонгор сумын 2 дугаар баг “Бичигт хад” гэх газарт Хяналтын 3 дугаар цэгт 24 цагийн үйл ажиллагаатай, сумдын Засаг даргын тамгын газрын ажилтан, байгаль хамгаалагч нар үүрэг гүйцэтгэж нийт 22 удаа 132 албан хаагчид ажиллаж, шаардагдах хоол, хүнс, томиллолт, ээлж	100%

	солих шатахууны зардалд 34,1 сая төгрөгийг зардал зарцуулаад байна.
--	---

ХЭРЭГЖИЛТ ХЯНАСАН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА П.БАТСҮХ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Г.ОТГОНЧИМЭД

